БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2020/149/СТА-ТШЗ**

---

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: О.Алтансүх
Утас: 99077045 Цахим хаяг: Altansukho52@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

Аудитын гэрчилгээ ........ 3

Аудитын тайлан ........ 5

2.1. Оршил ........ 5

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 5

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 6

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 6

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 7

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 7

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 7

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 8

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 9

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 9

2.13. Шилэн дансны мэдээлэл ........ 9

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ........ 9

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 10

Менежментийн захидал ........ **Error! Bookmark not defined.**

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ........ 11

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 11

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 12

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 13

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 15

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 15

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.20 № 1/143

танай _____________ -ны №_____________ -т

ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Р.БОЛОРМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020086

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2.1. Оршил

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Р.Болормаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.15-наас 2020.02.18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын гэрээт аудитор О.Алтансүх хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.23-ны өдрийн 2/02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн дагуу нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийгэм эдийн засгийн төлөвлөлтийг бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулан төрийн албан хаагчдын сахилга хариуцлага , шударга байдал, ур чадварыг дээшлүүлэн төрийн бүх үйлчилгээг чанарын шинэ шатанд гарахад оршино"

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг , нийгмийн бодлогын удирдлагын үйл
- Сум, багаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн ACOLOUS болон цалингийн Payroll программ" программ хангамж ашигладаг байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 33 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг " дунд," гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 460269,3 мянган төгрөгөөс тооцон 9205,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1259982,4 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 521,7 | 18,2 | -503,5 |
| Бараа материал | 29434,4 | 44911,6 | 15477,2 |
| Үндсэн хөрөнгө | 1016728,6 | 2261701,4 | 1244972,8 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 65699,8 | 68492,1 | 2792,3 |
| **Нийт хөрөнгө** | 1046684,8 | 2306631,3 | 1259946,5 |
| Өр төлбөр | 446,6 | 0 | -446,6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1046238,2 | 2306631,3 | 1260393,1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1046684,8 | 2306631,3 | 1260393,1 |

Бараа материалын дансны үлдэгдэл 15477,2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 29097,6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, бусад 18431,8 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 1231598,4 төгрөгөөр нэмэгдсэн нь Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын шинэ барилгыг данс бүртгэлд тусган авснаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө нь санхүүгийн программ 250,0 мянган төгрөг, газар 28138,0 мянган төгрөгийн өртөгтэй дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2306631,3 мянган төгрөг болж өмнөх оноос 1260393,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1260393,1 мянган төгрөгийн нэмэгдсэн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй болно.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 600.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 633.0 мянган төгрөгийн орлогыг үндсэн дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөг 101.0 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Төсөвт байгууллагын өөрийн орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Туслах үйл ажиллагааны орлогоор | 600.0 | 633.0 | 0.0 | 101.0 |
| **Нийт дүн** | 600.0 | 633.0 | 0.0 | 101.0 |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70106 кодтой нэг хөтөлбөрт зориулан 310104.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 375118,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 600.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 375118,2 мянган төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлогоос орох 633.0 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан авч үзэхэд тайлант онд Цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 247,1 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 33,0 мянган төгрөг хэмнэгдсэн нь нөлөөг үзүүлж байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 373846,4 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс 374846,4 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зарцуулж 304,7 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт төсвийн дансаар тайлант онд түрээсийн орлого 10906,0 мянган төгрөгийн төвлөрүүлж бараа үйлчилгээний бусад зардалд 9757,0 мянган төгрөг, бичиг хэрэгт 626,0 мянган төгрөг, 523,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 33 эрсдэл тодорхойлж нийт 33 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллээс хугацаанд нь 143 мэдээллийг , 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 10 | 1 | | |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 29 | 7 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | | | |
| | Нийт | 27 | 151 | 143 | 8 | | |

2019 оны тайлант онд бүтэн жилээр тавих худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн 1-р сар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийн 1, 12-р сар, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт гэсэн мэдээллийн 11-р сар, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ мэдээллийн 1, 4, 12-р сарын тус тус хугацаа хоцроосон байна.

Хугацаа хоцроосон тайлбарыг нягтлан бодогчоос авахад алдаатай буруу оруулсан мэдээллийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс шалгаж мэдээллийг засуулж оруулснаас хугацаа хоцроосноор бүртгэгдсэн байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**Аудит хийгдсэн санхүүгийн тайлан**

## 3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **29956215.00** | **44929944.00** |
| 31130 | Нэмэлт санхүүжилт | | |
| 33 | **АВЛАГА** | 521,764.00 | 18,289.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 482,364.00 | 18,289.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 29,434,451.00 | 44,911,655.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 21,826,451.00 | 43,921,655.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 465,500.00 | 675,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,360,951.00 | 43,246,155.00 |
| 35600 | Мал амьтад | 7,608,000.00 | 990,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,016,728,640.49** | **2,261,701,408.84** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,016,728,640.49 | 2,261,701,408.84 |
| 392 | **Биет хөрөнгө** | 988,580,223.67 | 2,233,552,992.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 990,509,664.69 | 2,240,403,964.69 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -174,117,107.99 | -174,879,794.36 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 144,942,800.00 | 153,202,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -67,412,506.59 | -82,498,997.32 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 227,274,333.00 | 192,580,954.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -164,102,706.94 | -138,424,864.37 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 41,778,085.00 | 49,915,600.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,292,337.50 | -6,746,670.62 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 28,148,416.82 | 28,148,416.82 |
| 39301 | Програм хангамж | 250,000.00 | 250,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -239,583.18 | -239,583.18 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 28,138,000.00 | 28,138,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,046,684,855.49** | **2,306,631,352.84** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,046,238,213.49** | **2,306,631,352.84** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,046,238,213.49 | 2,306,631,352.84 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 494,690,961.00 | 494,690,961.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 494,690,961.00 | 494,690,961.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 347,317,614.16 | 1,614,791,765.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 347,317,614.16 | 354,398,626.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,260,393,139.35 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 204,229,638.33 | 197,148,626.33 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,046,684,855.49** | **2,306,631,352.84** |

## 3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **370,347,575.00** | **1,720,662,529.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **46,661,500.00** | **1,335,208,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 46,661,500.00 | 1,335,208,300.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 46,661,500.00 | 1,335,208,300.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 723,500.00 | 633,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 45,938,000.00 | 1,334,575,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **323,686,075.00** | **385,454,229.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,728,000.00 | 10,906,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,728,000.00 | 10,906,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 301,424,200.00 | 374,518,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 301,424,200.00 | 374,518,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 533,875.00 | 30,029.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 533,875.00 | 30,029.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **382,869,530.85** | **428,053,313.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **382,869,530.85** | **428,053,313.43** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 375,313,624.85 | 425,448,587.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 183,806,123.00 | 209,927,555.00 |
| 210101 | Үндсэн цалин | 183,806,123.00 | 209,927,555.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,907,039.00 | 25,805,277.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,907,039.00 | 25,805,277.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,075,765.00 | 54,578,643.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,381,825.00 | 4,152,043.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,693,940.00 | 50,153,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 273,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,924,979.00 | 32,649,125.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,045,006.00 | 3,179,491.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,226,985.00 | 22,197,576.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,356,699.00 | 3,966,633.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 273,229.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 296,289.00 | 774,100.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 2,258,096.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26,340,000.00 | 6,618,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 26,340,000.00 | 6,618,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 617,100.00 | 4,158,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 617,100.00 | 4,158,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,600,000.00 | 11,572,050.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,600,000.00 | 7,705,800.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 3,866,250.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,213,555.00 | 6,354,832.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,213,555.00 | 6,339,832.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 15,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 73,829,063.85 | 73,784,405.43 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,129,200.00 | 5,247,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 45,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 65,699,863.85 | 68,492,155.43 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,555,906.00 | 2,604,726.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 533,875.00 | 880,029.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 533,875.00 | 30,029.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 850,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 304,789.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 304,789.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 522,031.00 | 1,419,908.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-12,521,955.85** | **1,292,609,215.57** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 11,356,400.66 | 32,216,076.22 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 11,356,400.66 | 32,216,076.22 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -11,356,400.66 | -32,216,076.22 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-23,878,356.51** | **1,260,393,139.35** |

### 3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **324,409,575.00** | **386,087,229.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **723,500.00** | **633,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 723,500.00 | 633,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 723,500.00 | 633,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 633,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **323,686,075.00** | **385,454,229.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,728,000.00 | 10,906,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,728,000.00 | 10,906,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 301,424,200.00 | 374,518,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 301,424,200.00 | 374,518,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 533,875.00 | 30,029.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 533,875.00 | 30,029.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **324,409,575.00** | **386,087,229.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **324,409,575.00** | **386,087,229.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **291,099,573.00** | **383,332,503.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 181,803,644.00 | 209,885,275.00 |
| 210101 | Үндсэн цалин | 153,239,644.00 | 174,893,175.00 |
| 210102 | Нэмэгдэл | 28,564,000.00 | 29,592,100.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 5,400,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,742,855.00 | 25,830,124.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,331,231.00 | 17,548,124.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,852,900.00 | 2,070,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,482,300.00 | 1,656,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 370,724.00 | 414,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,705,700.00 | 4,141,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,060,765.00 | 60,774,541.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,337,660.00 | 2,102,700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,723,105.00 | 58,488,841.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 183,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,062,825.00 | 22,672,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,343,345.00 | 2,705,371.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,438,580.00 | 15,060,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,034,000.00 | 3,953,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 299,829.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 246,900.00 | 654,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,617,100.00 | 35,615,730.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,560,000.00 | 10,000,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 23,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,057,100.00 | 2,415,730.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,920,000.00 | 11,622,050.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,920,000.00 | 7,627,300.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 3,994,750.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26,026,184.00 | 11,835,131.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,917,184.00 | 11,732,131.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 37,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 66,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,866,200.00 | 5,097,252.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,866,200.00 | 4,997,252.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 100,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **33,310,002.00** | **2,754,726.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,115,971.00 | 1,030,029.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 533,875.00 | 30,029.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,582,096.00 | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 304,789.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 304,789.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 522,031.00 | 1,419,908.00 |

## 3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **494,690,961.00** | **204,229,638.33** | **347,317,614.16** | 1,046,238,213.49 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **494,690,961.00** | **204,229,638.33** | **347,317,614.16** | 1,046,238,213.49 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 7,081,012.00 | 7,081,012.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **494,690,961.00** | **204,229,638.33** | **354,398,626.16** | 1,053,319,225.49 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -7,081,012.00 | 00.00 | -7,081,012.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,260,393,139.35 | 1,260,393,139.35 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **494,690,961.00** | **197,148,626.33** | **1,614,791,765.51** | 2,306,631,352.84 |

## 3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 375,118,200.00 | 374,846,411.00 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 375,118,200.00 | 374,846,411.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 374,118,200.00 | 373,846,411.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 209,941,200.00 | 209,885,275.00 |
| 210101 | Үндсэн цалин | 174,949,100.00 | 174,893,175.00 |
| 210102 | Нэмэгдэл | 29,592,100.00 | 29,592,100.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,400,000.00 | 5,400,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,021,300.00 | 25,830,124.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,739,300.00 | 17,548,124.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,070,500.00 | 2,070,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,656,400.00 | 1,656,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 414,100.00 | 414,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,141,000.00 | 4,141,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 60,783,700.00 | 60,774,541.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,102,700.00 | 2,102,700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 58,497,000.00 | 58,488,841.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 184,000.00 | 183,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,672,700.00 | 22,672,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,705,500.00 | 2,705,371.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,060,200.00 | 15,060,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,953,000.00 | 3,953,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 299,829.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 654,000.00 | 654,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 35,615,800.00 | 35,615,730.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 210602 | Тавилга | 23,200,000.00 | 23,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,415,800.00 | 2,415,730.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,627,300.00 | 11,622,050.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,627,300.00 | 7,627,300.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 4,000,000.00 | 3,994,750.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,356,200.00 | 2,349,039.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,251,200.00 | 2,246,039.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 39,000.00 | 37,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5100000.00 | 5097252.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000.00 | 4,997,252.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 100,000.00 | 100,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1000000.00 | 1000000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 375,118,200.00 | 374,846,411.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 374,518,200.00 | 374,213,411.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 374,518,200.00 | 374,213,411.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 600,000.00 | 633,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 633,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 1,020.00 | 58,301.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 555.00 | 7,878.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 455.00 | 4,545.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 45,878.00 |

### 3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **21748000.00** | **10,906,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21748000.00** | **10,906,000.00** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 523,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 523,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 626,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 626,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21748000.00 | 9757000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21748000.00 | 9,757,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21748000.00 | 10,906,000.00 |

**Аудитын тайланг**

**Хянсан:**

Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат 2018.02.18

Аудитын менежер А.Цээням 2018.02.18

6417143744
БЮА0217 9007423

**Бэлтгэсэн:**

Аудитор О.Алтансүх 2018.02.18